

АРДЧИЛАЛ, САЙН ЗАСАГЛАЛ (ДАНИЙН ТУРШЛАГА, МОНГОЛЫН ТУЛГАМДСАН АСУУДЛУУД, ХАМТРАН АЖИЛЛАХ БОЛОМЖ)

Д. Даваасамбуу¹

Миний биенэгд ардчилал, засаглалын талаарх Данийн Вант улсын тэргүүний туршлага, тэдгээрийг Монголд хэрэглэх боломж, хоёрт Монголын ардчилал, засаглалын талаарх тулгамдсан асуудлууд, гуравт Монголын ардчилал, засаглалыг сайжруулах талаар Данийн Вант улстай хамтран ажиллах боломж зэрэг асуудлаар зарим санаа, олсон мэдээллээ Та бүхэнтэй хуваалцаж, санал бодлыг сонсохыг хүсч байна. Чингэхдээ манай төрийн тогтолцоо, их хурлын гишүүд хэд байх, хоёр танхимтай парламент хэрэгтэй юу, сонгуулийн дараа засгийн газрыг хэрхэн бүрдүүлдэг болон парламент, засгийн газрын эрх үүргийн зааг, албан хаагчдыг улс төрчдийн нөлөөнөөс ангид байлгах боломж зэрэг манайд тулгамдсан асуудлаар санаа авахад хэрэгтэй гэж үзсэн зүйлүүдийг Дани улсын жишээн дээр ярихаар бэлдлээ.

Дани орныг эзэн хаантай Вант улс гэх боловч орчин цагийн орнуудын адил төлөөллийн ардчилалтай, дэлхийн тэргүүлэх соёлтой орон гэдгийг тэмдэглэхэд таатай байна. Дэлхийн ихэнх орнууд төлөөллийн ардчиллыг парламентаар дамжуулан хөгжүүлж байна. Ардчилал, засаглал өнөө үед парламентын дүр төрх, үлгэрлэлээс ихээхэн хамаарч байна. Энэ талаар ихээхэн туршлага хуримтлуулсан орон бол Данийн Вант улс билээ.

Дани нь Европын орнууд дотроо хамгийн хүчтэй парламентын засаглалтай орон гэж тооцогддог байна. Даничууд өөрсдийн парламентаа “Фолкетингет гэж нэрлэдэг ажээ. Манайх парламентаа “Их Хурал” гэж нэрлэдгийн адил гэсэн үг.

Данийн парламент манайх шиг нэг танхимтай. 1953 онд дээд танхимаа татан буулгасан байна. Хоёр танхимтай байх нь асуудлыг шийдвэрлэхэд улам хүндрэл учруулдгийг бодсон ч байж магадгүй. Дани өөрөө 5 сая гаруй хүнтэй харьцангуй жижиг, АНУ, Герман шиг Холбооны улс биш болохоор муж улсуудын төлөөллийг хангадаг сенатын буюу дээд танхим байх шаардлагагүй гэж үзсэн байх аа.

Харин Данийн Фолкетингетийн гишүүд нь хүн амын тоотойгоо жишихэд харьцангуй олон юм билээ. 179 гишүүнтэй, үүний 135 нь сонгуулийн тойргоос хувь тэнцүүлсэн пропорциональ системээр сонгогдоно. Үлдсэн 40 суудал нь намын авсан суудалд хувь тэнцүүлэн нэрсийн жагсаалтаас сонгоно. Цаана нь 4 суудлыг Фарое, Грийнланд гэдэг хоёр аралд хуваарилж, тэр бүс нутгийн парламент дахь төлөөллийг баталгаажуулжээ. Манайхаар төсөөлбөл Баян-Өлгий аймгийг баруун бүсийн сонгуулийн нэг тойрогт

¹ МУИС-ийн ОУХС-ийн багш, Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин

нэгэтгэвэл казах нөхөд маань гарах боломжгүй болох талтай. Иймээс Баян-Өлгийг нэг тойрог болгож, тэдэнд хоёр суудал хуваарилахтай агаар нэг юм. Хийсвэр, ирээдүйд байж болох жишээ гэдгийг ойлгоно биз ээ.

Манай зарим улс төрчид, судлаачид сонгуулийн хувь тэнцүүлсэн тогтолцооны нөхцөлд сонгуулийн олон тойроггүй, олон мандаттай тойрогт сонгогч мандат бүрийн тоогоор саналаа өгдөг тухай ярьдаг. Тэгвэл Данид олон мандат бүхий тойрогтой, мандатын тоо нь тухайн тойргийн хүн амын хэмжээнээс хамаардаг. Сонгогч бол тойрогт нь хэдэн ч мандат байхаас үл хамааран нэг л хүний төлөө саналаа өгнө. Үүнд л хувь тэнцүүлсэн пропорциональ системийн мөн чанар оршдог.

Намуудын парламентад оролцох сонгогчдын санал авах босго намтай орон бол Дани, тэднийх 2 хувь. Шведэд 4 хувь, манайд 5 хувь байдаг.

Дани улс өөрийн парламентад иргэд, улс төрийн хүчнүүдийн төлөөллийн, санал бодлыг илүүтэй тусгаж байхын тулд намууд сонгогчдын бага ч гэсэн санал авсан л бол парламентад суудалтай байх боломжоор хангажээ. Сонгогчдын 2 хувийн санал авсан л бол намуудад хуваарилах 40 суудлаас ганц ч гэсэн суудал олдоно гэсэн үг ээ. Ингэснээр улс төрийн намуудыг их бага гэлтгүйгээр төрийн хэрэгт оролцох боломжийг сайтар хангажээ.

Дани сонгуулийн хувь тэнцүүлсэн пропорциональ системтэй, намуудын иргэдийн санал авах босго намхан болохоор парламентад нь олон намын төлөөлөл оролцдог. Сүүлийн олон жил аль ч нам хүчин парламентад давамгайлсан олонхийн суудал авч чадаагүй ажээ. Тийм болохоор Данийн парламентын болон засаг төрийн ажлын нэг онцлог бол төр барьж байгаа болон сөрөг хүчний хооронд зөвшөлцөл, тохиролцооны зарчмаар явагддагт оршдог.

Данийн 2011 оны сонгуулиар парламентад суудалтай 8 намтай болсон байна. Нийт сонгогчдын 24,8 хувийн санал авч, 44 суудалтай болж, суудлын тоогоор хоёрдугаар байр эзэлсэн Данийн социал демократ намаас Ерөнхий сайдыг Данийн Хатан хаан томилжээ. Ерөнхий сайдтай болсон социал демократ нам нь социал либерал нам (17 суудалтай), социалист ардын нам (16 суудалтай), Улаан-ногооны эвсэл нам (12 суудалтай) болон бие даагчдын дэмжлэгтэйгээр засгийн газрыг байгуулжээ. Сонирхолтой нь хамгийн олон буюу 47 суудал авсан либераль нам засгийн газарт ороогүй байна. Энэ нь өөр нэг анхаарал татаж буй зүйлтэй холбоотой байж болзошгүй байх аа. Данийн үндсэн хуульд аливаа засгийн газар парламентад олонх байж болохгүй гэж заасан хэмээн ойлгосон. Ийм болохоор цөөнхийн засгийн газрын уламжлал Данид удаан хугацаанд хадгалагдаж байгаа бололтой. Гэхдээ засгийн газар бүрдүүлж буй нам нь парламентын бусад намуудтай хамтран олонх болдог байна. Тухайлбал, Данийн өмнөх засгийн газрын толгойлж байсан либераль нам нь консерватив нам, Данийн ардын намын дэмжлэгийг авч олонх болж байжээ. Гэхдээ Данийн ардын намаас засгийн газрын бүрэлдэхүүнд сайд ороогүй байна. Бодлогын тохиролцоог хийдэг болохоос биш манайхан шиг албан тушаалыг голлодоггүй бололтой.

Сонгууль болж, шинэ засгийн газрыг байгуулах үед Хатан хаан улс төрийн намын дарга нарыг хэлэлцүүлэгт урьдаг байна. Энэхүү хэлэлцүүлгээс зөвлөмж гаргадаг. Энэ зөвлөмжийг үндэслэн Хатан хаан засгийн газрыг бүрдүүлэх намын дарга буюу ирээдүйн ерөнхий сайдыг тогтоож өгдөг байна. Тэрээр засгийн газарт орж хамтран ажиллах намын удирдлагуудтай

тохиролцож, сайд нарын сонголтыг хийдэг. Кабинетын гишүүдийг парламентын гаднаас сонгох нь бий. Энэ бүхнээс үзэхэд манайхаас ялгаатай нэгэн зүйл анзаарагдаж байна. Энэ бол юу гэвэл засгийн газрыг бүрдүүлж, сонгоход Данийн парламентын оролцоо бараг байхгүй байна. Энэ бол хууль тогтоож, төрийг хянах голлох үүрэгтэй парламент, улс орны өдөр дутмын үйл ажиллагаа явуулдаг засгийн газар буюу гүйцэтгэх засаглалын үйл ажиллагааг өөр хооронд нь нэлээд сайтар салгасан жишээ мэт харагдаж байна. Ингэснээр засгийн газар нь парламентын өмнө хариуцлага хүлээж, тайлагнахад бие даасан шинжийг хадгалж байна. Парламент засгийн газраа өөрөө бүрдүүлчихээд түүнийгээ хянах нь хамтын хариуцлагын шинжтэй болдгийг салгасан хэрэг биз ээ. Данийн парламент засгийн газрын гишүүдийн сонсголыг авах, асуулга тавих, үнэлэлт дүгнэлт өгөх, хуулийн хэрэгжилтийг хангуулах, чуулганы хуралдаанаар хэлэлцэх, шаардлагатай үед засгийн газарт итгэл үзүүлэх эсэхийг хэлэлцэх зэргээр Засгийн газраа шахаж ажиллуулах олон механизм, эрх хэмжээтэй юм билээ.

Данийн Вант улсын эзэн хаан нь Британийн эзэн хаанаас илүү эрхтэй мэт санагдсан. Орчин цагийн Вант улсуудын хаан, хатад ёс төдий, бэлэгдлийн шинжтэй эрх хэмжээтэй болсон. Данийн үндсэн хууль ёсоор хаан бол төрийн тэргүүн, гүйцэтгэх болон хууль тогтоох засаглалын эрхийг хэрэгжүүлэгч болдог. Гэхдээ 1901 оноос эхлэн Парламентын бүрэн эрхийг бие даалгаснаас хойш хаан парламентын үйл ажиллагаанаас бүрэн хөндий болжээ. Тэхдээ л аливаа хууль, тогтоолд Данийн хатан хаан, засгийн газрын холбогдох сайдын гарын үсэг зайлшгүй хэрэгтэй болдог байна. Данид хааны тэргүүлэх эрх ямба гэж бий. Энэ нь засгийн газрын сайд нарыг томилох, дайн зарлах, энх тайвныг тогтоох эрх хэмжээг багтаадаг.

Эдгээр эрх хэмжээг Данид хатан хаан нь эдэлдэггүй ч гэсэн ерөнхий сайд, кабинет нь хэрэгжүүлэхдээ Хатан хаанаас формаль зөвшөөрөл авах учиртай.

Данид өнөө үед ч гэсэн хатан хаан нь дараах 3 формаль эрхтэй байдаг байна. Үүнд хатан хаантай зөвлөлдөх, хаан санал гаргах, хаан урьдчилан сануулах эрхүүд багтаж байна. Эдгээрийг мөрдөх үүднээс ерөнхий сайд, кабинетынхан төрийн зөвлөлийн ээлжит хуралдаанд оролцдог байна. Энэ зөвлөл нь өнөөдөр засгийн газрын сайд нарын формаль хуралдаан бөгөөд энэ хуралдаанд Данийн хаан хүү оролцдог. Үндсэн хууль ёсоор даргалагч нь хаан болно. Зөвлөлийн гол зорилго нь нэгд хууль эрх зүйн төслүүдийг парламентад оруулах дэмжлэг авах, батлагдсаны дараа хатан хаан болон хариуцсан сайдын гарын үсэг зурах урьдчилсан нөхцлийг хангахад оршдог байна. Гэхдээ хатан хаан гарын үсэг зурлаа гээд хариуцлага хүлээдэггүй байна.

Данид улс төрийн ажилтан, албан хаагчид хоёрын эрх хэмжээг сайтар ялгасан байна. Данийн яамдууд нь сайдын нарийн бичгийн дарга нарын газрын хэмжээнд ажилладаг. Яамдын ахлах ажилтнууд нь засгийн газар өөрчлөгдсөн ч ажлаа үргэлжлүүлэн хийдэг. Яамдын тэргүүн нь байнгын төрийн нарийн бичгийн дарга байдаг. Манайд уг нь ийм, гэвч бүрэн мөрдөгдөж чадахгүй байгаа юм.

Төрийн зөвлөлийн яам гэж бий. Тэр нь ерөнхий сайдын албан оффис, түүний байнгын нарийн бичгийн дарга төрийн албаны хамгийн том, хариуцлагатай албан тушаалтан ажээ. Харин сайдуудын хувийн нарийн бичгийн дарга, олон нийттэй харилцах ажилтнууд нь

намынх нь харъяаллын хүмүүс байдаг ажээ.

Ардчилал, сайн засаглал, хүний эрх, эрх чөлөөг эдлүүлэх, авилгыг хязгаарлах талаар Шинэ-Зеланд, Дани, Финланд, Швед зэрэг орнууд дэлхийд тэргүүлж байгаа гэж экспертүүд мэдээлж байна. Эдгээр орнууд өндөр хөгжилтэй, нэг хүнд ногдох бүтээгдэхүүнээр толгойлогч орнууд болохоор нийгмийн баялгийн шударга ёсны хуваарилалт, хүний эрх, эрх чөлөөг дээдэлж, төр засаг нь ариун тунгалаг, олон түмэнд нээлттэй, тэдний өмнө тайлагнаж, иргэд, иргэний нийгмийн оролцоо хяналтыг дээд хэмжээгээр хангаж ажиллаж чадаж байна гэж боддог.

Дани нь чадварлаг, сайн ажиллагаатай засгийн газартай ажээ. Ард түмэн нь Засгийн газраа авилгаас ангид байж, иргэдээ хамгаалагч гэж үздэг байна. Хоёр дахь дүгнэлт бол зөвшөлцөлд суурилсан ардчилалтай орон гэж үздэг байна. Амин чухал асуудлаар нийгмийн зөвшөлцөлд хүрэх чадвартай улс төрийн хүчин, улс төрчидтэй, засаглалын тогтолцоо нь ийм байх бүтэц, механизмтай ажээ.

Гурав дахь нь орчин цагийн чинээлэг нийгмийг цогцлуулсан цөөхөн орны нэг. Нийгмийн эмзэг хэсэг үнэхээр хамгаалагдсан. Хүний сурах, амьд явах бүрэн эрхийг үнэ төлбөргүй тогтолцоо, эмзэг бүлгийн нийгмийн хамгаалалтыг үнэхээр хангасан орон гэж дүгнэжээ. Эхлээд авилгатай хийж буй тэмцлийн талаар хөндөн ярьяа.

- Төсвийн орлого, зарлагыг олон нийтэд нээлттэй болгох нийгмийн баялгийг үр ашигтай зарцуулах хамгийн чухал арга зам гэж үздэг байна. Төсвийг төлөвлөх, батлах, гүйцэтгэлийг хангах зэрэг бүхий л явцад олон нийтийн оролцоог сайтар хангаж ажилладаг байна.
- Нийтийн албаныхан ажлаа эрхлэн явуулах ёс зүйн дүрэмтэй. Данийн бүх сайдууд сар бүхэн аялал, албан томилолт, бэлэг дурсгалын талаар нийтэд мэдээлэх үүрэгтэй. Дашрамд тэмдэглэхэд томоохон компаниуд орчин цагийн шаардлагад тохирсон ёс зүйн дүрэмтэй болсон. Энэ бол компанийн эзэд, удирдлага, ажилчдын хооронд харьцах хамгийн чухал хэрэгсэл. Үйлдвэрчний даргаас Их хурлын гишүүн болсон Ганбаатарт авах санаа тэнд их байгаа гэж бодож байна.
- Авилгын асуудлаар нэлээд өргөн хүрээг хамарсан эрүүгийн хариуцлагын заалтуудтай, бие даасан, сайн үйл ажиллагаатай шүүхтэй.
- Иргэд, нийгмийн байгууллагуудаас авилга, төсөв, нийгмийн баялгийн үрэн таран хийж буй зүй бус үйлдлийн тухай мэдээллийг хүлээн авах хотлайн утас ажиллуулах, шүүх хяналтын байгууллага мэдээлэл хүлээн авах цэг зэрэг арга хэмжээ авдаг байна.
- Авилгыг нийгмийн эсрэг гэмт гэж нэрлэдэг байна. Ийм болохоор үүнтэй нийгмээрээ тэмцэх ёстой гэдгийг олон нийтэд ойлгуулж, иргэдийг авилга, шударга бус явдлын эсрэг хийх тэмцэлд идэвхтэй оролцуулах уур амьсгалыг бүрдүүлэх нь чухал байна.
- Ардчиллын үнэ цэнийг нийтийн хүртээл болгоход Данид Канон (Danish Democracy Canon) нэртэй ардчиллыг зүгшрүүлэх хороо ажилладаг. Хорооны гишүүд нь голчлон эрдэмтэн мэргэд, сэтгүүлч байдаг. Энэхүү хороо буюу канон нь тогтмол уулзаж олон асуудал хэлэлцдэг юм билээ. Ардчиллын түүхэн замнал, үйл явдлууд, хөгжлийн үе шатууд, эрх чөлөө, хууль эрх зүйн болон нийгэмд хүлээгдэж, бас хүсэгдэж буй бусад олон асуудлаар ярилцлага, мэтгэлцээн хийдэг байна.

Дани нь нийгмийн хамгаалал, нийгмийн шударга ёс, нийгмийн баялагийг эрх тэгш хүртээмжтэй хуваарилдаг орон. Эдгээр үзүүлэлтээр дэлхийн 200 гаруй орнуудаас эхэнд буюу айргийн тавд тогтмол ордог улс юм. Үнэ төлбөргүй сургалт, эмчилгээг амжилттай хэрэгжүүлдэг баян орон. Ийм өндөр нийгмийн хариуцлага хүлээдэг болохоор хамгийн өндөр татвартай орон гэдгийг бид бас анхааралдаа авах ёстой Зах зээлийн эдийн засгийн уламжлал сайтай хөгжингүй орнуудад өндөр татвар, өндөр нийгмийн зардал, ачаалал байж болох талтай ч хөгжиж буй орнуудад ийм тогтолцоог мөрдүүлэхэд хүндрэлтэй байх болно. Хөгжиж буй орнууд эхлээд хөгжлийг дэмжиж суурь байгууламжаа бүрдүүлэх, хувийн хэвшлийг бэхжүүлэх зэрэг хөгжлийн олон сорилтуудыг давах учиртай болохоор нийгмийн том хариуцлагыг хүлээхэд хүндрэлтэй нь мэдээж ээ. Социализм байгуулах оролдлого хийж байсан үеэс улбаалан манай оронд нийгмийн ачаалал харьцангуй өндөр байдаг юм. ДНБ-ний 40-өөс доошгүй хувийг улс орны нийтийн болон нийгмийн хэрэгцээнд зарцуулах шаардлага гардаг юм. Нийгмийн зардал, түүнд зарцуулах хөрөнгө их байна гэдэг нь өөрөө хээл хахуул авилгыг нэлээд дагуулдаг. Дотоод ийм орчноос гадна манай хоёр хөрш бас их авилгатай оронд тооцогдож байгаа нь манай авилгачдад аятайхан хөрс болдог байх аа. Дотоодоосоо “хангалт” хийнэ гэхээр манай төрийн өмчид болон төсвийнхэн яаж ийгээд цааргалаад байдаг юм билээ. Худал, хуурамч баримт бүрдүүлэх, гадны хүнтэй үгсэн хуйвалдахад хялбар байдаг бололтой. Үүнтэй, авилгатай хил дамнан улс орнуудын хэмжээнд хамтран тэмцэх хэрэгтэй болно.

Скандинавын орнууд тэнд авилга багатай микро орчин бүрдүүлсэн нутаг. Сайхан орчин.

Монгол улс 2005 онд НҮБ-ын Авилгатай Тэмцэх Конвенцийг хүлээн зөвшөөрч, Авилгатай тэмцэх газрыг бие даасан статустайгаар байгуулсан. Сүүлийн жилүүдэд авилгатай тэмцэх талаар зохих ёсны тэмцэл хийж, бага ч гэсэн үр дүнд хүрч байна. Төсөв, төрийн үйлчилгээтэй холбогдсон мэдээллийг олон нийтэд ил болгох, иргэд, хэвлэл мэдээллийнхний мэдээлэл олж авах эрхийг хуульчилсан. Төрийн түшээд, албан хаагчид өөрсдийн орлого эд хөрөнгийг мэдээлэх, олсон хөрөнгийнхээ хууль ёсны баталгааг гаргах, төрийн алба хаахад ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх үүрэг хүлээх зэргээр олон арга хэмжээ авч байгаа. Гэхдээ бид хуулийг жигд тэгш хэрэглэж чадахгүй байх, хуулийн цоорхойг ашиглах явдлыг гаргуулахгүй байх, хууль тогтоомж нь өөрөө тодорхой бус байх зэрэг дутагдлууд байна. Нөгөө талаас эдийн засгийн бүлэглэлүүдийн дарамтад улс төрчид орсон тухай мэдээлэл их байна. Төрийн алба, албан тушаалыг зүй бусаар ашиглах явдал байсаар байгаа талаар иргэд шүүмжилж байна. Иймэрхүү зүй бус үйлдэлтэй тэмцэх талаар улс төрчид, төрийн удирдлагуудын улс төрийн эр зориг дутах нь байна. Энэ нь манай зарим улс төрчид бас өөрсдөө авилгын сүлжээ, хөрөнгө мөнгөний эрх ашигт орсон болохоор дорвитой, далайцтай тэмцэл хийж чадахгүй байгаа тал ч бий байх аа.

Ардчилал, засаглалыг сайжруулж үр дүнд хүрэхэд байнгын, тасралтгүй үйл ажиллагаа хэрэгтэй байна. Зарим хэвлэл мэдээллийн хэрэгсэл, улс төрчид, улс төрийн намуудыг хөрөнгө, мөнгөний эрхшээлээс гаргах арга зам, механизмыг оновчтой тогтоох явдал чухал байна. Шүүх, прокурор, мөрдөн байцаах болон хяналт шалгалт, авилгатай тэмцэх газруудын чадавх, бие даасан байдлыг хангах, мөн тэдний дураараа аашлах хуулийн

цоорхойг арилгах явдал тулгамдсан зорилт болж байна. Шүүхийн шийдвэрүүдийг хэвлэл мэдээлэлд ил тодоор хэвлэдэг журамд шилжих нь зүйтэй.

Шүүгчдийг улс төрийн зорилгоор ашиглах эрх зүйн үндэс манайд байгаа юм. Улс төрийн албан тушаалтан санал оруулдаг юм. Үндсэн хуулийн цэц, Төв банк, шүүх, прокурорын нэрсийг анхлан улс төрчид тогтоодог нь угаасаа тэднийг улс төрийн хүүхэлдэй болгодог байх аа. Дэлхий дахинд мэргэжлийн, бие даасан, төрийн болон бус байгууллагаар анхны сонголтыг хийдэг юм билээ. Данид хатан хаан бүх шүүгчдийг томилдог. Энэ нь ёс төдий шинжтэй. Учир нь Шүүх яам бүрэн эрхтэй засгийн газрын бус хоёр байгууллагыг байгуулж, шүүгчдийн сонголт, удирдлагыг бүрэн хариуцуулжээ. Энэ ажлыг 1999 оноос өмнө Шүүх яам хариуцаж байсан боловч олон янзын шүүмжлэлтэй тулгарч засгийн газрын бус байгууллагыг байгуулсан байна.

Данид Үндсэн хуулийн цэцгүй бөгөөд Дээд шүүхийн хүрээнд асуудал шийдвэрлэгдэнэ. Үндсэн хууль болон хууль эрх зүйн маргаантай асуудлыг засгийн газрын холбогдох яам, хууль хяналтын байгууллагын хүрээнд хамтран хэлэлцэж шийдвэрлэнэ.

Монгол улс өөрөө ардчилал, хэвлэл мэдээллийн эрх чөлөөг эрх зүйн болон улс төрийн хүрээнд чөлөөтэй болгосон орны хувьд амжилтад хүрнэ гэдэгт итгэлтэй байна. Өргөн шүүмжлэл ч явагдаж байна. Дани зэрэг улс орнуудаас ардчилал, сайн засаглалын үнэт зүйлсийн талаар суралцах зүйл бидэнд их байна. Тэдний туршлагыг судлах, хамтарсан төсөл хөтөлбөр хөгжүүлэх боломжийг судалж хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.